

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	13
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	15
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	16
3.7. Шилэн дансны мэдээлэл	17
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	19
4. Менежментийн захидал	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	21



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮҮХДИЙН ТӨВ НОМЫН САНГИЙН
ЗАХИРАЛ Б.ЭНХМАРТ ТАНАА

2021.02.25 № 07/583
танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүүхдийн төв номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт/, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүүхдийн төв номын сангийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Хүүхдийн төв номын сан нь тайлант онд 16 зорилтын хүрээнд 68 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.5 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд төвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>15,268,060.00</u>	<u>19,519,403.00</u>
33	АВЛАГА	52,800.00	6,361,403.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	52,800.00	154,386.00
33300	Татаас санхүүжилтийн авлага	00.00	5,699,120.00
335	Бусад авлага	00.00	507,897.00
3351	Байгууллагаас авах авлага	00.00	615.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	00.00	507,282.00
35	БАРАА МАТЕРИАЛ	15,215,260.00	13,158,000.00
351	Түүхий эд материал	8,256,390.00	6,528,681.00
35110	Тусгай зориулалттай материал	8,256,390.00	6,528,681.00
354	Хангамжийн материал	6,958,870.00	6,629,319.00
35410	Бичиг хэргийн материал	4,853,300.00	4,495,079.00
35420	Аж ахуйн материал	739,370.00	768,040.00
35470	Бусад хангамжийн материал	1,366,200.00	1,366,200.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>557,432,854.29</u>	<u>615,561,166.45</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	557,432,854.29	615,561,166.45
392	Биет хөрөнгө	557,432,854.29	615,561,166.45
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21,000,000.00	21,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,000,000.00	-21,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	104,098,445.50	105,018,445.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	-97,190,318.10	-98,340,099.10
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	89,619,447.82	89,619,447.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-76,469,327.05	-79,557,189.54
39217	Ном	537,374,606.12	598,820,561.77
39301	Програм хангамж	4,179,100.00	4,179,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-4,179,100.00	-4,179,100.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>572,700,914.29</u>	<u>635,080,569.45</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>111,763.74</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	111,763.74	00.00
413	Өглөг	111,763.74	00.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	111,763.74	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>572,589,150.55</u>	<u>635,080,569.45</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	572,589,150.55	635,080,569.45
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/	398,693,113.63	398,693,113.63
51101	Өмч: - төрийн	398,693,113.63	398,693,113.63
512	Хуримтлагдсан үр дүн	135,954,942.03	163,742,094.28
51210	Өмнөх үеийн үр дүн	100,993,435.54	135,954,942.03
51220	Тайлант үеийн үр дүн	34,961,506.49	27,787,152.25
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	37,941,094.89	72,645,361.54
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>572,700,914.29</u>	<u>635,080,569.45</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	676,776,579.19	731,673,665.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	32,452,295.07	24,329,845.00
120	Нийтлэг татварын бус орлого	32,452,295.07	24,329,845.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32,452,295.07	24,329,845.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	32,452,295.07	24,329,845.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	644,324,284.12	707,343,820.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	594,356,300.00	688,502,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,356,300.00	688,502,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,967,984.12	18,841,620.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,618,750.00	13,292,870.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,244,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,105,234.12	5,548,750.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	634,422,891.70	698,055,105.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	634,422,891.70	698,055,105.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	626,687,036.44	622,139,832.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	363,213,295.58	389,966,874.52
210101	Үндсэн цалин	363,213,295.58	389,966,874.52
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,287,746.32	50,420,041.18
210201	Тэтгэврийн даатгал	32,634,473.90	35,046,221.14
210202	Тэтгэмжийн даатгал	3,701,661.37	4,132,487.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,864,053.70	3,134,629.62
210204	Ажилгүйдлийн даатгал	644,321.67	732,719.11
210205	Эрүүл мэндийн даатгал	6,443,235.69	7,373,983.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,047,200.00	137,047,200.00
210304	Байрны түрээс	134,047,200.00	137,047,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	52,734,091.06	30,533,323.80
210401	Бичиг хэрэг	7,711,539.00	3,154,071.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,852,285.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,622,902.74	5,614,078.80
210404	Ном, хэвлэл	1,386,450.31	33,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	485,500.00	786,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,486,900.00	3,358,230.00

210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	30,540,799.01	15,735,659.00
2105	Нормативт зардал	00.00	1,568,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,568,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,398,200.00	00.00
210604	Урсгал засвар	2,398,200.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	5,913,281.00	00.00
210702	Дотоод албан томилолт	5,913,281.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,273,078.00	8,366,750.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,532,098.00	2,513,850.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,480.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	97,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	2,660,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	00.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,820,144.48	4,237,643.49
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,820,144.48	4,237,643.49
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,735,855.26	75,915,272.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,266,730.00	72,728,565.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	72,628,565.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,266,730.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	469,125.26	3,186,707.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	469,125.26	3,134,407.76
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		52,3000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>42,353,687.49</u>	<u>33,618,559.25</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	7,392,181.00	5,831,407.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	7,392,181.00	5,831,407.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-7,392,181.00	-5,831,407.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>34,961,506.49</u>	<u>27,787,152.25</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>644,324,284.12</u>	<u>707,343,820.00</u>
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	644,324,284.12	707,343,820.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	594,356,300.00	688,502,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	594,356,300.00	688,502,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	49,967,984.12	18,841,620.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	9,618,750.00	13,292,870.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,244,000.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,105,234.12	5,548,750.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>615,349,834.12</u>	<u>686,622,569.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	615,349,834.12	686,622,569.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	607,613,978.86	605,008,176.24
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	362,936,644.12	390,548,371.74
210101	Үндсэн цалин	284,295,744.12	266,143,629.74
210102	Нэмэгдэл	38,320,900.00	85,071,362.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,320,000.00	39,333,380.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,275,700.00	50,559,175.70
210201	Тэтгэврийн даатгал	32,170,900.00	35,185,875.70
210202	Тэтгэмжийн даатгал	3,526,200.00	3,843,300.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,821,000.00	3,074,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	705,200.00	768,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	7,052,400.00	7,686,700.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,200.00	137,047,200.00
210304	Байрны түрээс	137,047,200.00	137,047,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	19,960,452.74	14,221,778.80
210401	Бичиг хэрэг	5,485,350.00	2,504,500.00
210402	Тээвэр, шатахуун	2,500,000.00	1,852,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,622,902.74	5,614,078.80
210404	Ном, хэвлэл	1,366,500.00	33,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	485,500.00	820,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,500,200.00	3,397,300.00
2105	Нормативт зардал	1,645,000.00	1,645,100.00

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,645,000.00	1,645,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,491,200.00	00.00
210604	Урсгал засвар	2,491,200.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	5,913,281.00	00.00
210702	Дотоод албан томилолт	5,913,281.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	31,344,501.00	10,986,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,603,521.00	3,633,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	3,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,480.00	95,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	93,500.00	97,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,000,000.00	2,660,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,735,855.26	81,614,392.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,266,730.00	72,728,565.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	72,628,565.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,266,730.00	100,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	469,125.26	8,885,827.76
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	469,125.26	3,134,407.76
213305	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг		5,751,420.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>28,974,450.00</u>	<u>20,721,251.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	28,974,450.00	20,721,251.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,974,450.00	20,721,251.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,974,450.00	20,721,251.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,974,450.00	20,721,251.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-28,974,450.00</u>	<u>-20,721,251.00</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	100,993,435.54	537,627,644.06
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.0	00.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	100,993,435.54	537,627,644.06
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	34,961,506.49	34,961,506.49
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	135,954,942.03	572,589,150.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	398,693,113.63	37,941,094.89	135,954,942.03	572,589,150.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	34,704,266.65	00.00	34,704,266.65
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	27,787,152.25	27,787,152.25
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	398,693,113.63	72,645,361.54	163,742,094.28	635,080,569.45

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	688,507,200.00	685,367,792.24	3,139,407.76	99.5%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	688,507,200.00	685,367,792.24	3,139,407.76	99.5%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	615,356,900.00	612,639,227.24	2,717,672.76	99.6%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	384,335,100.00	383,798,371.74	536,728.26	99.9%
210101	Үндсэн цалин	259,144,300.00	259,393,629.74	-249,329.74	100.1%
210102	Нэмэгдэл	84,870,800.00	85,071,362.00	-200,562.00	100.2%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,320,000.00	39,333,380.00	986,620.00	97.6%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	51,885,100.00	49,715,425.70	2,169,674.30	95.8%
210201	Тэтгэврийн даатгал	36,511,800.00	34,342,125.70	2,169,674.30	94.1%
210202	Тэтгэмжийн даатгал	3,843,300.00	3,843,300.00	0.00	100.0%
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,074,700.00	3,074,700.00	0.00	100.0%
210204	Ажилгүйдлийн даатгал	768,600.00	768,600.00	0.00	100.0%
210205	Эрүүл мэндийн даатгал	7,686,700.00	7,686,700.00	0.00	100.0%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	137,047,700.00	137,047,200.00	500.00	100.0%
210304	Байрны түрээс	137,047,700.00	137,047,200.00	500.00	100.0%
2104	Хангамж, бараа материалын зардал	34,948,900.00	34,943,029.80	5,870.20	100.0%
210401	Бичиг хэрэг	2,504,500.00	2,504,500.00	0.00	100.0%
210402	Тээвэр, шатахуун	1,852,900.00	1,852,900.00	0.00	100.0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,619,400.00	5,614,078.80	5,321.20	99.9%
210404	Ном, хэвлэл	20,754,800.00	20,754,251.00	549.00	100.0%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	820,000.00	820,000.00	0.00	100.0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,397,300.00	3,397,300.00	0.00	100.0%
2105	Нормативт зардал	1,645,100.00	1,645,100.00	0.00	100.0%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,645,100.00	1,645,100.00	0.00	100.0%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,495,000.00	5,490,100.00	4,900.00	99.9%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	410,000.00	410,000.00	0.00	100.0%

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,824,900.00	1,824,900.00	0.00	100.0%
210803	Даатгалын үйлчилгээ	95,400.00	95,400.00	0.00	100.0%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,400.00	97,500.00	4,900.00	95.2%
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,562,300.00	1,562,300.00	0.00	100.0%
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.0%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	73,150,300.00	72,728,565.00	421,735.00	99.4%
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,150,300.00	72,728,565.00	421,735.00	99.4%
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	73,050,300.00	72,628,565.00	421,735.00	99.4%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	100,000.00	0.00	100.0%
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	688,507,200.00	685,367,792.24	3,139,407.76	99.5%
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	688,507,200.00	685,367,792.24	3,139,407.76	99.5%
131001	Улсын төсвөөс санхүүжих	688,507,200.00	685,367,792.24	3,139,407.76	99.5%
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	32	32	0	100.0%
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0%
620002	Гүйцэтгэх ажилтан	23	23	0	100.0%
620003	Үйлчлэх ажилтан	8	8	0	100.0%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/ төгрөгөөр /			
Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		18,841,620.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		18,841,620.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		13,090,200.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		6,750,000.00
210101	Үндсэн цалин		6,750,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		843,750.00
210201	Тэтгэврийн даатгал		843,750.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		5,496,450.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		3,223,650.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		1,175,100.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		1,097,700.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		5,751,420.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		5,751,420.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		18,841,620.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		18,841,620.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		13,292,870.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,548,750.00
131106	Төсвийн урамшуулал		00.00

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хүүхдийн төв номын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Хүүхдийн төв номын сангийн захирал Б.Энхмарт танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд цалингийн тооцооллыг зөв хийж тооцооллын алдаа гаргахгүй байх, цалин бодохдоо цагийн бүртгэлтэй тулгаж байх, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангуудыг үнэн зөв тайлагнах, өр авлага үүсгэхгүй байх талаар өгсөн зөвлөмжийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Си Пи Ти Эй аудит ХХК-ны захирал Ч.Энхчимэг аудитор Д.Сүнжидмаа нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүүхдийн төв номын сангийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Си Пи Ти Эй аудит ХХК -т 2021 оны 01 сарын 20 -ны өдрийн 02.дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн төв номын сангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Нийтэд үйлчлэх 6 танхим, хүүхэд залуучуудад үйлчлэх 13 зөөврийн номын сангаар дамжуулан:

- Уншилгийн танхимын үйлчилгээ
- Гэрээр ном олгох үйлчилгээ
- Зөөврийн номын сангийн үйлчилгээ
- Цахим номын сангийн үйлчилгээ
- Соёл олон нийтийн ажил
- Лавлагаа мэдээллийн үйлчилгээ
- ЕБСургуулийн номын санчдад сургалт, арга зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг тус тус үзүүлж байна.

2. Ерөнхий удирдлага арга зүйн хүрээнд:

- Хүүхдийн номын сангийн сан хөмрөгийг шинэчлэх, хадгалалт хамгаалалтыг сайжруулах,
- Хүүхдийн төв номын сангийн үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх шинэчлэлт хийх,
- Хүүхдийн ном хэвлэлийн архивын болон мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагаа зэрэг болно.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- ХХОАТТХуулийн хөнгөлөлт шатлалын хэмжээнд өөрчлөлт орсон байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хүүхдийн төв номын сан нь санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Соёлын яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд Хүүхдийн номын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийх төлөвлөгөөтэй байсан боловч цар тахлын нөхцөл байдлын улмаас хойшлогдсон байна..

Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар шилэн дансны хөтлөлт 82.6%, байршуулсан мэдээллийн үнэн зөв, бодитой, иж бүрэн байх зарчмыг хангасан байдлын хэрэгжилт 75.2% -тай гэж дүгнэсэн байна.

Соёлын яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 703,886.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 7,038.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүүхдийн төв номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 62,491.5 мянган төгрөгөөр буюу 11 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, эздийн өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	52.8	6,361.4	6,308.6
Бараа материал	15,215.3	13,158.0	-2,057.3
Үндсэн хөрөнгө	557,432.8	615,561.2	58,128.4
Нийт хөрөнгө	572,700.9	635,080.6	62,491.5
Өр төлбөр	111.8	0.0	-111.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	572,589.1	635,080.6	62,491.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	572,700.9	635,080.6	62,379.7

Авлага дансны үлдэгдэл 6,361.4 мянган төгрөг болж 6,308.6 мянган төгрөгөөр өссөн нь цалингийн тооцоолол хийхдээ алдаа гаргаснаас хувь хүнээс авах цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 662.3, нэмэлт санхүүжилтын төвлөрүүлсэн дүн 5,699.1 мянган төгрөгийн авлага үүссэнээс тус тус шалтгаалжээ.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 15,215.3 мянган төгрөг байсан бол тайлант хугацаанд 9,458.3 мянган төгрөгийн худалдан авалт, Соёлын яамнаас 11,558.0 төгрөгийн үнэ төлбөргүй хүлээн авсан бараа материалын дүнгээр нэмэгдэж, 23,073.6 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, 13,158.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Бараа материалын дансны үлдэгдэлд 2020 онд худалдаж авсан ашиглагдаагүй 4,495.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 2,134.2 мянган төгрөгийн аж ахуйн материал, 6,528.8 мянган төгрөгийн тусгай зориулалтын материал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 615,561.2 мянган төгрөг болж 58,128.4 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн дагуу номын фондод худалдан авалт хийсэн 20,721.3 мянга, иргэн аж ахуй нэгж байгууллагаас 11,851.8 мянга, Германы хөрөнгө оруулалттай Гёте институтээс 920.0 мянган төгрөгийн хандив, үнэ төлбөргүй шилжиж ирсэн хөрөнгөөр болон хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 34,704.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна. Мөн тайлант хугацааны элэгдлийн зардал 4,237.6 мянга, ТӨБЗГазрын 2020 оны 05 сарын 12-ны А-380 тоот шийдвэрээр 5,831.4 мянган төгрөгийн акталсан хөрөнгөөр тус тус буурсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 111.8 мянган төгрөгөөр буурсан нь оны эхний үлдэгдэл болох ХХОАТ-ын өглөгийг төлснөөс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 635,080.6 мянган төгрөг болж 62,491.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Хүүхдийн төв номын сангийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 54,897.1 мянган төгрөгөөр буюу 8.11 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого байна. Энэ нь тус байгууллагаас тэтгэвэрт гарсан 3 ажилтны тэтгэмжийн мөнгөний санхүүжилттэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 63,632.2 мянган төгрөгөөр буюу 9.12 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалин 26,753.6 мянга, нийгмийн даатгалын шимтгэл 4,132.3 мянга, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал 65,461.8 мянга төгрөгөөр тус тус өссөн, харин бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 5,906.3 дотоод томилолтын зардал 5,913.3 шуудан холбоо интернэтийн төлбөр 11,033.4 аж ахуй материал худалдан авах зардал 14,805.1 мянган төгрөгөөр тус тус буурсан нь ковидын нөхцөл байдлаас шалтгаалжээ.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 811,530.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 811,530.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 123,022.8 мянган төгрөгөөр бууруулж 688,507.2 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөл өмнөх оны төсвөөс цалин,

нийгмийн даатгалын шимтгэл, эд хогшил худалдан авах зардал, нормативт зардлуудыг нэмэгдүүлэн төсөвлөсөн байна. Засгийн газрын 354, 263, 25-р тогтоолоор 35 орон тоогоор ажиллах бөгөөд 32 орон тоогоор ажиллаж байгаа жил бүрийн төсвийн төсөлд саналаа оруулдаг боловч батлагддаггүйн улмаас ажилтнууддаа хавсран ажилласны нэмэгдэл 40% олгон ажилладаг байна. Эд хогшил худалдаж авах зардлын хувьд уншигчдын ширээ сандал шинээр худалдан авахаар төсөвлөсөн зардал хасагдсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 16 хөтөлбөрийн 68 арга хэмжээг санхүүжүүлэхээр 688,507.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 688,507.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 688,502.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 685,367.8 мянган төгрөгийг зарцуулж 3,134.4 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 685,367.8 мянган төгрөг буюу 99.5 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 536.7 мянган төгрөгөөр, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,169.7 мянган төгрөгөөр, тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмжийн зардлыг 421.7 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 13,292.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 5,548.7 мянга, нийт 18,841.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалинд 6,750.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлд 843.7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн төлбөр хураамжийн зардалд 5,496.5 мянга, нийт 13,090.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 5,751.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 115 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 26 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 20.7 мянган төгрөгийн 1 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	20.7	1	20.7	0	0	100%
Нийт дүн	1	20.7	1	20.7	0	0	100%

/мянган.төг/

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20,639.5 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс, 9,065.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 11,574.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, 1 албан шаардлага өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Анхан шатны баримтын бүрдэл дутуу 8,499.6 гүйлгээ хийснийг илрүүлж аудитын явцад холбогдох байгууллага, иргэдээс и баримтыг авч хавсарган зөрчилгүй болгосон.
2. Нэг ажилтны цалинг илүү тооцоолж олгосонтой холбогдуулж ХХОАТ-н тайланг 58.5 мянган төгрөгөөр залруулж, гарт олгосон 507.3 мянган төгрөгийн цалинг суутгах, нийт 565.8 мянган төгрөгийн авлага үүсгэв.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй ба шилэн дансанд нийт 22 нэр төрлийн мэдээллийг 149 талбарт оруулахаас 26 талбарт хугацаа хоцроосон, 11,420.6 мянган төгрөгийн 1 мэдээг мэдээлээгүй орхигдуулсан зөрчлийг арилгах 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Шилэн дансанд байршуулах мэдээллийг 82.6 хувьтай байршуулсан нь мэдээллийн үнэн зөв бодитой, иж бүрэн байх зарчмыг хангасан байх байдлыг дүгнэхэд 11,420.6 мянган төгрөгийг 1 мэдээг мэдээлээгүй орхигдуулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1 “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3 “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 153.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Хүүхдийн номын сангийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Цалингийн данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Ажилчдын цалинг тооцохдоо цагийн бүртгэлтэй тулгалт, хяналт хийгээгүйгээс ээлжийн амралт авсан ажилчны хоногийг хасалгүй давхардуулан олгосноос 153.5 мянган төгрөгийн зөрчил илэрсэн. Энэ зөрчил нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “Үнэн зөв байх” зарчим, 20 дугаар зүйлийн 20.2.4-д нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Эрсдэл:

Цалингийн зардал илүү тооцогдох, нийгмийн даатгал, ХХОАТ тайлан зөрүүтэй тайлагнах эрсдэлтэй

1.3. Өгсөн зөвлөмж

Цалингийн тооцооллыг зөв хийж тооцооллын алдаа гаргахгүй байх, цалин бодохдоо цагийн бүртгэлтэй тулгаж байх, нийгмийн даатгал, ХХОАТ-ын тайлангуудыг үнэн зөв тайлагнах, өр авлага үүсгэхгүй байх. 2020 оны Нийгмийн даатгалын тайланг засварлах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын захирал, нягтлан бодогч нар танилцаж хүлээн зөвшөөрсөн болно.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хүүхдийн төв номын сангийн захирал Б.Энхмарт, нягтлан бодогч Г.Оюунтунгалаг болон холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хүүхдийн төв номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021.02.20			САГ-2021/75/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хүүхдийн төв номын сан		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Цалингийн тооцооллыг давтан гүйцэтгэж шалгахад ээлжийн амралттай хоногийг давхардуулан тооцсоноос нийгмийн даатгалын байгууллагаас авах авлага үүссэн.	153.5	Зөвлөмж	Захирал Нягтлан бодогч	Б.Энхмарт Г.Оюунтунгалаг
2	Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээ мэдээллийг мэдээлэхгүй орхигдуулсан, хугацаа хоцроосон.	11,420.6	Албан шаардлага	Захирал Нягтлан бодогч	Б.Энхмарт Г.Оюунтунгалаг
ДҮН		11,574.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 203/АО/70068

Улаанбаатар хот

САН-2021/75/СТА-ПЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хүүхдийн номын сангийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллагын шилэн дансны цахим хуудаст байршуулах нийт 22 нэр төрлийн мэдээллийг 149 талбарт оруулахаас 26 талбарт хугацаа хоцроосон мөн 11,420.6 /арван нэгэн сая дөрвөн зуун хорин мянга зургаан зуу/ төгрөгийн 1 мэдээг мэдээлээгүй орхигдуулсан байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж мэдээллийг ил тод, цаг хугацаанд нь бүрэн байршуулж, биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хүүхдийн төв номын сангийн захирал Б.Энхмарт, нягтлан бодогч Г.Оюунтунгалагт даалгав.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁР ДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТОР
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭГЧ:
СИ ПИ ТИ ЭЙ АУДИТ ХХК-ИЙН
ЗАХИРАЛ

М.Дашдаваа

Б.Энхмарт

Ц.НАРАНЧИМЭГ
Ч.ДАШДАВАА

Ч.ЭНХЧИМЭГ

This image shows a full page of a handwriting practice worksheet. It consists of approximately 20 horizontal rows. Each row is defined by two parallel dotted lines, creating a series of uniform gaps for writing. The lines are evenly spaced across the entire page, providing a guide for letter height and placement. There is no text or other markings on the page.